



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#3 (12)

2023 он

III сар

Сар тутмын хэвлэл


 <http://www.mnier.mn>

**"Монголын боловсрол судлал", "Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог" монограф бүтээлийн танилцуулга-уулзалт боллоо.**




Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Академич Надмидын Бэгз, философи-түүхийн шинжилгээ бүтээл МОНГОЛЫН БОЛОВСРОЛ СУДАЛ, МОНГОЛ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДАР, НИЙГЭМШИЛ, ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ монограф хамтын бүтээлийн танилцуулга-уулзалт 2023 оны 3 сарын 24 нд Багшийн хөгжлийн ордонд боллоо.

Монгол Улсад боловсрол судлалын шинэ дэг сургууль үүсэн хөгжиж ирсэн 33 жилийн үр дүнг нэгтгэн бичсэн нэг сэдэвт бүтээл.



Манай ахмад үеийнхний бий болгосон сурган хүмүүжүүлэх ухааны судалгаа, сургалтын өв дээр суурилж, хүн амын насан туршийн боловсролын шинэ тогтолцооны онол, үзэл баримтлалыг агуулсан боловсролын үйл ажиллагааг олон шинжлэх ухааны уулзварт судлах боловсрол судлалын онол, аргазүйн шинэ үеийг (1990-2023) номын 4 бүлэгт хураан бичжээ. Энэ бүтээлээс гадаад орнууд дахь боловсрол судлалын үүсэл, хөгжил, монголын боловсролын судалгааны эх сурвалж, түүхчилсэн үе шатууд, МУ-ын боловсрол судлалын шинэ тогтолцооны үүсэл, хөгжил, монголын боловсрол судлалын хөгжлийн цаашдын төлөвийн тухай, манай улсад 1958-2021 онд хамгаалсан боловсрол судлалын диссертацийн судалгаануудтай танилцаж болно.

Номын тухай: Н.Бэгз (2023). Монголын боловсрол судлал. Соёмбо Принтинг, УБ, 280х.



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Хүний хөгжлийн судалгааны хамт олон монгол хүүхдийн 2 удаагийн (2014-2022) цогц судалгааныхаа үр дүнгээр нэг сэдэвт бүтээл гаргалаа. Монгол Улсын боловсролын тогтолцоо нь монгол суралцагчдынхаа онцлогийг тооцож, сургалтын агуулга, аргазүй, үнэлгээ зэргийгээ бий болгох нь зорилгоо хэрэгжүүлэх үндэс нь болох ёстой гэж үзээд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн БШУЯ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр 2014-2022 онд монгол хүүхэд, залуучуудын хөгжлийн цогц судалгааг 2 үе шаттайгаар хэрэгжүүллээ.

Судалгааг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийг нас бүрээр тодорхойлох аргачлалуудыг хөгжүүлж, үндэсний хэмжээнд төлөөлөхүйц, цаашдаа баяжуулж чанаржуулахуйц мэдээллийн сан бий болголоо. Мөн 3-17 нас бүрээр бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн зарим чадварууд, тэдгээрийн өөрчлөлтийг тогтоолоо. Үүний үр дүнд цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн сургалтын олон талт үйл ажиллагаанд хүүхэд залуучуудын хөгжлийн онцлогийг оношлох, үр дүнд нь тэдний хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдлээ. Энэ бүтээл нь судлаач, оюутан, цэцэрлэг, сургуулийн багш нарт гарын авлага болох үнэтэй мэдээлэл агуулсан, монгол хүүхдийн хөгжлийн 2 удаагийн судалгааны үзүүлэлтүүдийг нас насанд нь харьцуулж харуулсан судалгааны том ажлын үр дүнгээр гарч байгаа юм.

Номын тухай: Н.Бэгз, Н.Санжаабадам, С.Энхбаяр, Б.Баярмаа, Б.Лхагвасүрэн, Ц.Мөнхбат, Ш.Баясгалан, (2023). Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог. Соёмбо Принтинг, УБ, 269х.

### СӨБ-ын "Амьдралын мод" сургалтын хөтөлбөрийг турших судалгаа



Туршилтын болон хяналтын нийт 16 цэцэрлэгээс бэлтгэсэн асуулга, хүүхдийн даалгаврын дагуу 178 багш, 839 хүүхдээс мэдээлэл цуглуулж дата мэдээллийг ангилах, цэвэрлэх, кодлох ажлыг хийв. Мөн туршилтын 8 цэцэрлэгт мониторинг хийж хөтөлбөрийн туршилтын үйл явцтай танилцав.

Мониторинг болон гарааны үнэлгээний хүрээнд цуглуулсан мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийж БШУЯ болон туршилтын 8 цэцэрлэгийн удирдлагуудад судалгааны явцыг

танилцуулав.

### ЕБС-ийн математик суралцахуйг дэмжих Eduten платформыг турших судалгаа



Eduten платформын туршилтын явцтай танилцах, харилцан туршлага солилцох онлайн уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтад туршилтын 15 бүлгийн багш нар, сургуулийн удирдлагууд, БШУГ-ын мэргэжилтнүүд, Eduten технологийн компанийн мэргэжилтэн, БСҮХ-ийн судлаачид оролцож, туршилтын явцын үр дүн, тулгарч байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэж байгаа арга туршлагаадаа солилцож, мэргэжилтнүүдийн зүгээс зөвлөмж, мэдээллээр хангалаа. Мөн туршилтын гарааны үнэлгээний мэдээллийг нэгтгэж, үр дүнг боловсруулж дуусав.

туршилтын гарааны үнэлгээний мэдээллийг нэгтгэж, үр дүнг боловсруулж дуусав.

## Их, дээд сургуулийн “Багш, бага боловсрол” жишиг бакалаврын хөтөлбөрийг боловсруулав



“Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEOS), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOS), сургалтын арга зүй, багшлах бүрэлдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийн эхний хувилбарт санал авч сайжруулж байна. Мөн сургалтын төлөвлөгөөнд тусгах хичээлийн хөтөлбөрийн агуулгыг судалж байна.

“Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн эхний хувилбарыг боловсруулав. Сургалтын төлөвлөгөөг боловсруулах 2 хоногийн сургалт

хийж эхний хувилбарыг боловсруулав.

## СӨБ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын төлөвлөгөөт уулзалтыг зохион байгуулав

БШУЯ, БСҮХ, БҮТ, БЕГ-ын 2023 оны 1-р улиралд хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулах, цаашдын хамтран ажиллах чиглэлээ тодорхойлох уулзалтыг БСҮХ-ийн БСХҮСБС секторын СӨБ хариуцсан ЭША-ууд БШУЯ-ы 111 тоотод 3 сарын 24-ий өдөр зохион байгууллаа.

Байгууллагууд 2023 оны 1-р улиралд хийж гүйцэтгэсэн ажлаа танилцуулж цаашид хэрхэн хамтран ажиллах чиглэлийг ярилцсан нь байгууллагуудын үйл ажиллагаа тодорхой, хамтын ажиллагаа бэхжих боломжийг бий болгосон.

## DACUN олон улсын аргаар ажлын стандарт боловсруулах багийн уулзалт болов

Цэцэрлэгийн арга зүйч, багш, туслах багшийн хийдэг ажлыг гаргаж боловсруулалт хийсэн байдалд 3 багаар уулзаж ярилцсан. Уулзалтын явцад гарсан саналын дагуу цэцэрлэгийн туслах багшийн ажлын стандартын баримт бичгийг уншиж сайжруулалт хийв.

Ажлын байрны стандартын эхний хувилбарыг шинжээчдэд (эксперт) уншуулах ажил явж байна.

## Бага насны хүүхдийн сүлжээ байгууллагуудын уулзалтад оролцов

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төрийн болон төрийн бус байгууллагуудын уулзалтыг улирал бүр зохион байгуулдаг бөгөөд 1-р улирлын уулзалтаар “Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” БШУЯ, ХНХХЯ, ЭМЯ-ы сайд нарын тушаалаар батлагдсаныг НҮБ-ын Хүүхдийн сан, БШУЯ танилцуулав.

Уулзалтын үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан төлөвлөж хамтран ажиллах үйл ажиллагааг 2023 онд НҮБ-ын Хүүхдийн сан чиглүүлэн ажиллахаар шийдвэрлэв.



### Судлагдахуун ба хэлийг интеграцчилан суралцахуйг нэвтрүүлэх“ зөвлөх үйлчилгээний үр дүнгийн тайлан хүргэгдсэн.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын эрх олгосноор БСҮХ-ийн захирал Дэлхийн банкны Бага боловсролын чанарын шинэчлэл төсөлтэй “Судлагдахуун ба хэлийг интеграцчилан суралцахуйг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Уг гэрээний дагуу 5 чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, дараах үр дүнд хүрлээ.

- ① Хос хэлт сургалтыг тандсан судалгааны мэдээллийн сантай болж, хос хэлний боловсролын бодлогын чиглэл тогтоох мэдээлэлтэй болсон.
- ② Сонгогдсон сургуулиудын багш нар, БШУГ-ын мэргэжилтнүүд АХИС-г хэрэгжүүлэх чадавхтай болсон. Мөн АХИС арга зүйг Баян-Өлгий аймгийн туршилтын 2 сургуулиас бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх сургагч багш нарыг бэлдэх 3 өдрийн сургалт амжилттай зохион байгуулагдав. Сургалтаар АХИС арга зүйг түгээх 34 сургагч багшийг бэлтгэж, батламж олгов.
- ③ Эх хэлээрээ бага боловсрол эзэмшиж буй Баян-Өлгий аймгийн 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан монгол хэлний жишиг/стандарт хөтөлбөртэй болсон ба хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сурагчийн ном, дасгал ажлын дэвтрийг боловсруулсан.
- ④ Сонгогдсон судлагдахууны хос хэл дээрх хичээл төлөвлөлтийг боловсруулсан ба сургалтын хэрэглэгдэхүүний сантай болсон.
- ⑤ Эх хэл дээрээ боловсрол эзэмшээгүй бүх насны тува (цаатан) үндэстэнд зориулсан эх хэл, соёлын жишиг хөтөлбөр боловсруулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай суралцагчийн гарын авлагатай болсон.

Зөвлөх үйлчилгээний дээрх чиглэл бүрийн хүрээнд хийсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг Дэлхийн банканд хүргүүлэн ажилласан.

### "Нана Ноно" олон ангит хүүхэлдэйн контентэд арга зүйн зөвлөгөө өгөв



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд ирүүлсэн албан бичгийн дагуу Хэнтий аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хийгдэж буй “Нана Ноно” олон ангит хүүхэлдэйн контенттой танилцав.

2021 оноос Хэнтий аймагт 8 хүний бүрэлдэхүүнтэй “Нана Ноно” төсөл нь хүүхэлдэйн киногоор дамжуулж цэцэрлэгт хамрагддаг болон хамрагдах боломжгүй хүүхдүүдэд хөгжилтэй хэлбэрээр боловсрол олгох зорилгоор 2021 онд эхэлсэн болно. 2022 оны 7 сараас


“Dreambox” телевиз болон “Нана Ноно” нэртэй youtube сувгаар хүүхэлдэйн контентоо түгээж эхэлжээ. Тус төслийн хүрээнд 21 контент, 18.0 сая гаруй хандалт авч, улсын хэмжээний 2 телевизийн сувгаар өдөр бүр гаргадаг байна. Албан бичиг бүхий танилцуулгаар ирсэн 17 хүүхэлдэйн клип, 18 хуудас бүхий буддаг номтой танилцаж холбогдох арга зүйн санал зөвлөмжийг хүргүүлэв.




**СӨБ болон ЕБС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгж өртгийн тооцоолол судалгааны ажлаар Хэнтий аймгаас эхлэв.**



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал” батлах тухай 91 дүгээр тогтоолын дагуу хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлалыг сайжруулах сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгж өртгийн тооцоолол



судалгааны ажлаар 03 дугаар сарын 20-24-ны хооронд Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль, Хэрлэн сумын хоёрдугаар цэцэрлэг, Жаргалтхаан сумын 9 жилийн дунд сургуулиудад ажиллаж, шаардлагатай мэдээллийг цуглуулав.



Тус ажлын хүрээнд цэцэрлэг, сургуулиудын статистик үзүүлэлтүүд, 2021-2023 оны төсөв, болон төсвийн гүйцэтгэл, “төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах”; “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах”; “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах”; “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх”-г үндэслэн зардлыг төлөвлөж, хуваарилсан санхүүжилтийн байдал, гүйцэтгэлийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлтөд цагийн тооцоолол хийх зэргээр ажилласан болно.

## БМДИ-ийн мэргэжил дээшлүүлэх сургалтын “ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ” хөтөлбөрт шинжилгээ хийсэн ажлын тайлан

### 1. ҮНДЭСЛЭЛ


- Хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч, боловсрох эрхийн олон улсын болон МУ-ын боловсролын хууль, эрх зүйн бодлогын баримт бичгийн үзэл санаа, БМДИ-ийн сургалтын бодлогод нийцсэн байдал
- Хөтөлбөрт тэгш хамран сургах багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлсон байдал

### 2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Багш нараас, тэгш хамруулах боловсролын чиглэлээр хэр зэрэг системтэй мэдлэг авсан байдлыг асуулгын аргаар (2021 оны 12 сарын 18) судалгаа авч тодруулсан.


Зураг №1-ээс харахад хамгийн олон буюу багш нарын 69.68 хувь нь системтэй мэдлэг өгсөн, хамгийн бага буюу 28.19 хувь үгүй гэж хариулсан нь БМДИ-ийн тусгай хэрэгцээт, тэгш хамруулах боловсролын сургалт тодорхой зорилгоо хангаж иржээ.

Зураг №1. ТХБ-ын сургалтын системтэй мэдлэг өгсөн байдал



ТХБ-ын талаарх багш нарын ойлголтын өнөөгийн байдлыг тодруулахаар асуулгын аргаар (2021 оны 12 сарын 18) судалгаа авсан. Судалгаанд ЕБС, тусгай сургууль, цэцэрлэгийн 26-56 насны нийт 188 багш хамрагдсан.

Зураг №2. Багш нарын ТХБ-ын талаарх өөрийн үнэлгээний байдал



Зураг №2-оос харахад багш нарын хамгийн олон буюу 49,47 хувь сайн, хамгийн бага буюу 2,66 хувь хангалтгүй гэж үнэлсэн байна. Багш болон БМДИ-ийн тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас үзэхэд: сургуулийн өмнөх, бага боловсролын багш нарын ойлголт харьцангуй сайжирсан, харин суурь боловсролын багш нарын ойлголт төдийлөн сайн биш тул сургалтын агуулгыг энэ тал дээр төвлөрүүлэх хэрэгтэй нь харагдаж байна.

Тус ажлын хүрээнд цэцэрлэг, сургуулиудын статистик үзүүлэлтүүд, 2021-2023 оны төсөв, болон төсвийн гүйцэтгэл, “төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах”; “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах”; “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах”; “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх”-г үндэслэн зардлыг төлөвлөж, хуваарилсан санхүүжилтийн байдал, гүйцэтгэлийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлтөд цагийн тооцоолол хийх зэргээр ажилласан болно.

### 3. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН


**Мэдлэг:** Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал, олон улсын чиг хандлага, өөрийн орны эрх зүйн орчин хэрэгжилтийг үндсэн мэдээлэл хэлбэрээр лекцээр танилцуулдаг.

**Чадвар:** Багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, арга зүйн хувилбарыг туршин хэрэгжүүлэх дадлага ажил, туршлага солилцох хэлэлцүүлгийн цаг хөтөлбөр төлөвлөдөг (59.2%), Хувийн ур чадварт чиглэсэн 22.2% агуулгыг төлөвлөсөн байна.

**Хандлага:** МДҮС-ын дараа сургалтаар олж авсан мэдлэг чадвараа ажлын байрандаа хэрэгжүүлсэн хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, үйл ажиллагааны тайланг ирүүлэх замаар эргэх холбоотой ажилладаг.

Сургалт хариуцсан мэргэжилтэн хөтөлбөрийн хандлагын байдлыг сургалтын дараа эргэх холбоотой, хамтарч ажилладаг байдлаар тодорхойлсон байдлыг, багш нараас, сургалтын дараа багш нарт дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан бэ? асуулгын аргаар (2021 оны 12 сарын 18) судалгаа авч тодруулсан.

Зураг №3. Сургалтын дараа багш нарт дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан байдал



Зураг № 3 - аас харахад хамгийн их 57.45 хувь дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг, 42.02 хувь дэмжлэг үзүүлээгүй гэж хариулсан тул цаашид анхаарч, олон хувилбарт байгууллага, хувь хүний онцлогт тохирсон төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Тэгш хамруулах боловсрол нь тасралтгүй үргэлжлэх үйл явц, шинэ үзэл баримтлал тул сургалтад оролцогчдод тэгш хамруулах боловсролын ач холбогдол, түүний философи, социологи, сэтгэл зүй, эдийн засгийн үндэслэлийг тайлбарлах, ХБХ, гэр бүлийн сэтгэл зүй, нөхцөл байдлыг ойлгох, хүндэтгэх, дэмжин туслах хандлага эерэг хандлага төлөвшүүлэхэд анхаарч хөтөлбөр, хичээлд тусгайлан тодорхойлж, үүнд чиглэсэн ажлыг төлөвлөх нь зүйтэй гэж үзлээ.

### 4. ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Сургалтыг мэргэжлийн ялгаатай байдал, ажилласан жил, хот хөдөөгийн байдлаар ангилан сургалт явуулах оролдлого хийж үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Сургалт бүрийн хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, зохион байгуулах хэлбэр, байршил зэргийг дадлага явуулах байдлаа харгалзан тусгасан нь хэрэгжих боломжтойгоор тооцсон байна.

2021 онд бүх сургалт цахим зайн хэлбэрээр зохион байгуулагдсан. Ковидын нөхцөл байдлын үед багш сурагчдад тулгарч буй бэрхшээлийг хэлэлцэж, цаасан суурьтай сургалтын материал бэлтгэх, зайн хэлбэрээр сургалт зохион байгуулахаас гадна сургалтын материал хүргэх, эцэг эхээр дамжуулан сурагчдад хүрч ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтын явцад жишиг хөтөлбөр боловсруулах дадлага ажлууд хийсэн.

Зураг №4. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарын гүнзгийрүүлэн судлах агуулгын байдал



Зураг №4 - аас харахад багш нар ХБХ-ийн сэтгэл зүйн онцлог, хүүхдийн оношилгоо, үнэлгээ, заах арга зүйн асуудлыг илүү сонирхож судлах хүсэлтэйгээ илэрхийлсэн байна.

Дээрх судалгааны үр дүнгүүдээс харахад багш нарт сэтгэл судлал, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны суурь үндсэн асуудлыг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ үүссэн байгаа нь харагдаж байгаа тул МДМ-ын агуулгыг эргэн харах шаардлагатай байна.

Үндсэн сургалтын агуулгад судлагдахууны хөтөлбөрт ТХБ –ын агуулга, цагийг нэмэгдүүлэх, тухайн судлагдахууны болон тусгай хэрэгцээт боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ( оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд монгол хэл, математик заах арга зүй гэх мэт) сургалтын дидактик заах арга зүйг холбон, хөтөлбөр боловсруулах ажлыг үе шаттай хийх ажлыг үе шаттай эхлүүлэх нь зүйтэй. Тодорхой арга зүйн шийдэлтэй сургалтын модуль байхгүй байгаа нь сургалтын агуулгын логик дараалал муу байгааг илтгэж байна. Мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгаас харахад зарим талдаа агуулгыг тохиолдлоор сонгож сургалт явуулдаг, тухайн нэг агуулгаар мэргэшсэн сургагч багшийн нөөцгүй байгаа нь мэргэжил дээшлүүлэх сургалтын чанарт сөргөөр нөлөөлдөг байна гэх үндэслэлтэй байгааг анхаарч сайжруулах хэрэгтэй.

Цаашид дараах агуулга тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Тэгш хамруулах боловсролын үндсэн асуудлууд
- Монгол улс дахь тэгш хамруулах боловсролын хөгжил, асуудал, шийдэл
- Тэгш хамруулах боловсролын нөхцөл дэх цогц дэмжлэгийн асуудал
- Тэгш хамруулах боловсролын багшийн үйл ажиллагаа
- Тэгш хамруулах боловсролын технологи